



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгаар
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



**“Цахим сургууль – цахим сургалт” хөтөлбөрийн
хэрэгжилт, үр дүн.**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулаагүй
бөгөөд хэрэгжилтэд тавих хяналт- үнэлгээ хангалтгүй байна.

Сүхбаатар сум 2017 он

Тайланг бэлтгэсэн:**Сэлэнгэ аймаг дахь
Төрийн Аудитын газар****Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа****Аудитын менежер
Б.Батмөнх****Ахлах аудитор
Б.Наранчимэг****Аудитор
Ж.Цогт****2017 оны 09-10 сар**

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7036-3036 дугаарын утас, 7036-3040 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд

Агуулга

Нэг. Товчилсон үгийн жагсаалт

Хоёр. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Гурав. Ерөнхий мэдээлэл

Дөрөв. Аудитын дүн

Бүлэг 1: Хөтөлбөрийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн үү?

1.1. *Хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бодитой байсан уу?*1.2. *Хөтөлбөрийн зорилтыг хэрэгцээ, шаардлагатай нийцүүлэн тодорхойлж чадсан уу?*1.3. *Хөтөлбөрт шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөсөн үү?*

Бүлэг 2: Хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн үү?

2.1. *Хөтөлбөрийн санхүүжилт шийдэгдэж, зорилтууд бүрэн хэрэгжсэн үү?*2.2. *Хөтөлбөрийн хэрэгжилтэд үр нөлөө бүхий хяналт хийгдсэн үү?*2.3. *Хөтөлбөрийн үр дүнг бодитоор үнэлж, дүгнэж тайлагнасан уу?***Тав. Аудитын дүгнэлт****Зургаа. Зөвлөмж****Хавсралтууд****Холбогдох байгууллагын санал**

Нэг. Товчилсон үгийн жагсаалт

Аймгийн ИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам
БСУГ	Боловсрол, Соёл урлагын газар
БСГ	Боловсрол, соёлын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбоо технологи

Хоёр. АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудитын нэр:

“Цахим сургууль-Цахим сургалт” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

2. Аудитын код:

СЭА-2017/05/-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө болон аймгийн ИТХ-ын захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

4. Аудитын зорилт:

“Цахим сургууль-цахим сургалт” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Хөтөлбөрийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн үү?
2. Хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн үү?

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитаар “Цахим сургууль- цахим сургалт” хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ, БСУГ болон ерөнхий боловсролын 34 сургуулийг хамруулан шалгав.

6. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа. (Асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт №2, 3-т үзүүлэв)

7. Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 24 дүгээр тогтоол. /Цахим сургууль- цахим сургалт” хөтөлбөрийг батлах тухай /
- Бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, үе шатны болон явцын хяналтыг аудитын менежер Б.Батмөнх хэрэгжүүлэн, ахлах аудитор Б.Наранчимэг, аудитор Ж.Цогт 2017 оны 09 дүгээр сарын 04-нөөс 10 дугаар сарын 10-ны хооронд төлөвлөгөө, хөтөлбөр, хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Гурав. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор “Цахим сургууль- цахим сургалт” хөтөлбөрийг 2 үе шаттай хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд нэгдүгээр үе шат нь 2013-2015 оны хичээлийн жилд, хоёрдугаар үе шат нь 2015-2017 оны хичээлийн жилд хэрэгжихээр тогтоосон байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд аймгийн 34 ЕБС-ийг шилэн кабель, WiFi сүлжээнд холбон, нийт 2374,945.3 мянган төгрөгийн компьютер, техник , тоног төхөөрөмжөөр хангасан байна.

Дөрөв. АУДИТЫН ДҮН

Бүлэг 1. Хөтөлбөрийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн үү?

1.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бодитоор оршиж байсан байна.

Аливаа улс орны хөгжлийн түлхүүр нь хүний хөгжилдөө оршдог учраас боловсролын системийг шинэчилж, чанартай боловсрол олгох, сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий сургалтын орчинд сургах, хүүхэд багш бүрийг компьютертэй болгох, компьютерийн мэдлэг дадлага, эзэмших боломжоор хангах, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг мэдээллийн технологийн тусламжтайгаар шинэ түвшинд гаргах зайлшгүй шаардлага бий болж байна.

Дээрх шаардлагын дагуу Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, МУ-ын болон аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлд мэдээллийн технологийг сургалтад нэвтрүүлэх зорилтыг дэвшүүлжээ.

Мэдээллийн технологийг сургалтад нэвтрүүлэх зорилтод нийцүүлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 24 дүгээр тогтоолоор “Цахим сургууль-Цахим сургалт” хөтөлбөр батлагдсан байна.

Мэдээлэл технологийг сургалтад ашиглах бодлого, чиглэл боловсруулж, эрх зүйн орчинг бүрдүүлэх төрийн бодлоготой уялдан “Цахим сургууль-Цахим сургалт” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага урган гарчээ. Үүнд:

- 2013 оны байдлаар аймгийн хэмжээнд дунджаар 29 хүүхдэд нэг, 3 багшид нэг компьютер ногдож байсан
- Нийт 34 ЕБС-ийн 34.2 хувь нь л шилэн кабельд холбогдсон.
- ЕБС-дад ашиглагдаж байгаа техник хэрэгслүүдийн 81.6 хувь нь техник технологийн хувьд хоцрогдсон, элэгдлээ бүрэн нөхсөн байсан байна.

МУ-ын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан **“Эрдэм боловсролтой Монгол хүн”** хөтөлбөрт “мэдээллийн технологийг сургалтын орчинд өргөнөөр ашиглах...” зорилтыг дэвшүүлсэн байна.

1.2 Хөтөлбөрийн зорилтыг өнөөгийн хэрэгцээ, шаардлагатай нийцүүлэн тодорхойлж чадсан байна.

“Эрдэм боловсролтой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн 4 тэргүүлэх чиглэл, 8 зорилттой уялдуулан “Цахим сургууль-Цахим сургалт” хөтөлбөрт 4 зорилт, 16 арга хэмжээг тусгажээ. Үүнд:

- МХХТ-ийн дэд бүтцийг хөгжүүлэх
- Боловсролын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх:
- Багш нарын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх:
- МХХТ-ийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтыг суралцагчдын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан зохион байгуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх:

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Мэдээлэл, харилцаа холбоо технологийн дэвшлийг ерөнхий боловсролын сургуулиудын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, багш, сурагцагчдын МХХТ-ийг хэрэглэх чадварыг дээшлүүлэх, багш, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх явдал юм.

1.3 Хөтөлбөр боловсруулахдаа уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн төсвийг хамт тооцож, төлөвлөөгүй байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний төсөв шаардлагатай боловч уг хөтөлбөрийг анх батлахдаа түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн нийт эх үүсвэрийн хэмжээ, төсөвт өртгийг хамт тооцоолж, төлөвлөөгүй байна.

Харин эх үүсвэрийг зөвхөн хаанаас, ямар байгууллагаас бүрдүүлэх вэ гэдгийг л зааж өгсөн байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг:


- 1.Улсын төсвийн хөрөнгө
 - 2.Орон нутгийн төсвийн хөрөнгө
 - 3.Хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгө, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
 - 4.Бусад гэж тодорхойлсон байна.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгахыг бүх шатны Засаг дарга нарт даалгажээ.

Цаашид шинээр батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгах шаардлагатай байна.

Бүлэг 2. Хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн үү?

2.1 Хөтөлбөр хэрэгжсэнээр аймгийн дүнгээр нэг багшид нэг, 14 хүүхдэд нэг компьютер ногдож байна.

Хөтөлбөрийн хүрээнд 2014-2016 оны байдлаар улсын төсвөөс 1,491.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 63,4 сая төгрөгийн, хандив тусламжаар 820,3 сая төгрөгийн зэрэг нийт 2,375.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс улсын төсвийн хөрөнгө оруулалт 62.8 хувь, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 2.7 хувь, хандив тусламж 34.5 хувийг эзэлж байна.



“Цахим сургууль- Цахим сургалт” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг хөтөлбөрийн хамт тооцож, батлаагүй боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.491,3 сая төгрөгийн өртөг бүхий зөөврийн компьютер болон бусад тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн нь нийт хөрөнгө оруулалтын 63%-ийг эзэлж байна. / Нийлүүлэгдсэн техник хэрэгслийг эх үүсвэр, нэр төрлөөр хавсралт 1-д дэлгэрэнгүйгээр харуулав/

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр аймгийн хэмжээний бүх багш нар зөөврийн компьютераар хангагдаж, 14 хүүхдэд нэг компьютер ногдон, цахим сургалтын орчин сайжирснаар цаг хугацаа, орон зайнаас үл хамааран багш нар дараах цахим сайтад нэвтрэн, өөрсдийн мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, сургалтад ашиглагдах мэдээ мэдээллийг олж авах зэрэг давуу талууд бий болсон байна. Өөрөөр хэлбэл, “Цахим сургууль- цахим сургалт” хөтөлбөр хэрэгжиж, зохих хэмжээнд үр дүнгээ өгсөн байна. Үүнд:

- Багш нар багшийн хөгжлийн “www.teacher.sur.mn” сайтад бүртгүүлж өөрийн бэлтгэсэн цахим хичээлийг байршуулах болон бусад багш нарын бэлтгэсэн цахим хичээлийг судалж өөрийн хичээлд ашиглах,
- Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын “esurgalt.itpd.mn” багшийн цахим сургалтын төвд нэвтрэн ЕБС-д эхний 5 болон 10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын үндсэн сургалт болон багшийн эрх олгох сургалтыг цахим хэлбэрээр өгөх,
- Боловсролын салбарын мэдээллийн систем www.esis.edu.mn сайтад аймгийн 34 ЕБС-ийн багш, суралцагч, ажилчид, удирдах ажилтны судалгаа, дотуур байранд амьдарч байгаа болон сургуульд суралцдаггүй хүүхдийн судалгаа, шилжих хөдөлгөөн, сурагчдын жилийн эцсийн болон улсын шалгалтын дүнг оруулах боломжтой болсон байна.
- ЕБС-ийн төгсөх ангийн сурагчид Боловсролын үнэлгээний төвийн www.eec.mn сайтаар элсэлтийн ерөнхий шалгалтад бүртгүүлэхээс гадна Их дээд сургуулиудын консорциумын гишүүн сургуулиудын онлайн элсэлтийн www.eec.edu.mn цахим хуудсыг ашигладаг болсон байна.
- Багш, сурагчид улсын хэмжээний мэдээлэл зүйн олимпиад, программ хангамжийн уралдаан, тэмцээнд амжилттай оролцож шагналт болон тэргүүн байрыг эзэлсэн
- байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт нь тоон талаасаа хангалттай, нэг багш, сурагчид ногдох техник тоног төхөөрөмжийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй боловч хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж байгаа зарим техник, тоног төхөөрөмжийн чанарын талаар аудитын явцад асуулга, тодруулга авахад хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна гэсэн тайлбар өгч байлаа./ Аудитын явцад Сүхбаатар, Мандал сумдын ЕБС-ийн багш нараас ярилцлага авсан болно / Тодруулбал:

- *ЕБС-уудын багш нарт өгсөн зөөврийн компьютер нь ажлын ачаалал даах чадвар муутай, хоёроос гурван программ зэрэг ашиглахад гацдаг, нэмэлт программ үйлдлийн систем суулгахад ажилладаггүй.*
- *Шилэн кабель нь салаалж тавихад хурд удааширдаг.*
- *Wifi нь интернет цацах зай хязгаарлагдмал учраас анги танхим бүрийг хангаж чаддаггүй зэрэг дутагдалтай тал байна.*

Хөтөлбөр ёсоор тухайн шатны Засаг дарга нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах үүрэг хүлээсний дагуу 2014 онд сумдыг интернэтэд холбох, WiFi сүлжээ тавих зардалд 567,4 сая төгрөг, техник хэрэгслийн зардалд 63,4 сая төгрөгийн буюу нийт санхүүжсэн дүнгийн 3 хувийг аймгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байна.

Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг батлаагүйгээс зарим ажил, арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн боловч зогсонги байдалд орсон байна. Тухайлбал:

- Шилэн кабельд холбогдсон сумдын сургуулийг интернэтэд холбох, бусад сургуулиудад WiFi сүлжээ байгуулах зорилтын хүрээнд санхүүгийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс Түнхэл, Номгон тосгод,Тарни багийн сургуулиуд интернэтэд холбогдоогүй байна.
- Сургууль бүр цахим хуудастай болох зорилтыг хэрэгжүүлэхэд цахим хуудасны хаяг нь өндөр өртөгтэй, сайжруулахад өндөр зардал шаардагддаг тул бүх сургуулиудын цахим хуудас хаагдсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн компьютер, техник хэрэгслийн ашиглалтын хугацаа нь 2018-2020 онд дуусч байгаа тул цаашид уг хөтөлбөрийг тасралтгүй үргэлжлүүлэх, боловсронгуй болгох, өргөтгөхөд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг ирэх онуудын төсөвт суулгах, бусад эх үүсвэрийн боломж, арга замыг судлан ажиллах зайлшгүй шаардлага үүсч байна.

2.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд дотоод хяналт шалгалт, үнэлгээ хийгдээгүй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ хийж байхыг аймгийн Боловсролын газар / тухайн үеийн нэршилээр / -т даалгасан боловч тус газраас зөвхөн хөтөлбөрийн явц, хэрэгжилтийн мэдээ тайланг нэгтгэн гаргахаас бусдаар үйл ажиллагаанд нь хяналт- үнэлгээ хийгдээгүй байна.

Хөтөлбөрийн 10.3 дахь “ Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар хөтөлбөрийн баг Боловсролын газрын зөвлөлийн хуралд жилд нэг удаа танилцуулж, дүгнэлт гаргуулна” гэсэн заалтын дагуу хөтөлбөрийн багийг томилон, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавиулахаар зохицуулагдсан боловч уг багийг албан ёсоор байгуулаагүй, өөрөөр хэлбэл “Цахим сургууль- цахим сургалт” хөтөлбөрийн үйл явц, хэрэгжилтэд ямар ч хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд дотоод хяналт шалгалт, үнэлгээ хийгдээгүйгээс шалтгаалж, хөтөлбөрийн бүрэн хэрэгжсэн болон хэрэгжээгүй заалт, түүнд нөлөөлж буй хүдрэл, бэрхшээл, цаашид авах арга хэмжээ зэргийг нарийвчлан тодорхойлж чадаагүй байна.

Бид аудитын явцад аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 34 сургуулиас хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар судалгаа авч нэгтгэн гаргасан бөгөөд Сүхбаатар, Мандал сумдын ЕБС-дад хөтөлбөрийн хэрэгжилт ямар түвшинд байгаа талаар газар дээр нь очиж шалган, аймгийн БСГ-ын / тухайн үеийн нэршлээр / тайлан мэдээтэй тулган баталгаажуулалт хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Мэдээлэл харилцаа технологийг нэвтрүүлсэн загвар цахим сургууль бий болгохыг бүх талаар дэмжих, цахим сургуулийн тоог нэмэгдүүлэх гэсэн зорилтын хувьд цахим сургууль шинээр бий болоогүй байхад хэрэгжилтийг 50.0 хувь гэж тайлагнасан./ хэрэгжсэн гэж тайлагнасан Сүхбаатар сумын 1-р бүрэн дунд сургууль нь уг хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө цахим сургууль болсон байна /
- Төсөв, хөрөнгийн хүндрэлээс шалтгаалж ихэнх сургууль цахим хуудас нээж ашиглаагүй буюу 14 сургууль цахим хуудас нээж, хэрэгжилт 41,2 хувьтай байхад хэрэгжилтийг 90.0 хувь гэж тайлагнасан байна.

2.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-т

нэг ч удаа хүргүүлээгүй байна.

“Цахим сургууль-Цахим сургалт” хөтөлбөр нь 2013-2015 он, 2015-2017 оны хичээлийн жил гэсэн 2 үе шаттай хэрэгжихээр батлагдсан бөгөөд 1-р шатны хэрэгжилтийн явц, үр дүнг аймгийн ИТХ-ын 2016 оны 09-р сарын 14-ны өдрийн 14-р хуралдаанд оруулж, хэлэлцүүлсэн байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон гүйцэтгэлийн тайланг зорилт тус бүрээр аймгийн БСГ-/ тухайн үеийн нэршлээр/-аас гаргаж хэлэлцүүлсэн байна.

Хөтөлбөрийн 10-р зүйлд “Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хөтөлбөрийн баг Боловсролын газрын зөвлөлийн хуралд жилд нэг удаа танилцуулж дүгнэлт гаргуулна”, “Боловсролын газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жилийн эцэст аймгийн ЗДТГ-т хүргүүлнэ” гэж заасан боловч тайлан, мэдээг аймгийн ЗДТГ-т нэг ч удаа хүргүүлээгүй байна.

Аймгийн БСГ-аас хөтөлбөрийн 1-р шатны хэрэгжилтийн явц дунджаар 95.6 хувьтай хэрэгжсэн гэж тайлагнаж, аймгийн ИТХ-аас хөтөлбөрийн хэрэгжилтийг “Сайн” гэж үнэлсэн байна. / хавсралт 2-р хөтөлбөрийн биелэлтийг харуулав/

БСГ-аас / тухайн үеийн нэршилээр / хөтөлбөрийн биелэлтийг зорилт, арга хэмжээ тус бүрээр нэгтгэн гаргасан дүн, мэдээг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Ажил арга хэмжээний тоо	Биелэлт					
		Биелсэн		Дутуу биелэлттэй		Зорилт тус бүрээр	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1-р зорилт	8	5	100	3	76.3	8	91.2
2-р зорилт	2	2	100			2	100
3-р зорилт	4	4	100			4	100
4-р зорилт	2	2	100			2	100
Нийт	16	13	100			16	95.6

Хэдийгээр хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн БСГ-аас 95,6 хувь, аймгийн ИТХ-аас “Сайн” гэж үнэлж, дүгнэсэн боловч энэ нь хяналт, шинжилгээ, үнэлгээн дээр бус зөвхөн БСГ-аас нэгтгэн гаргасан тайлан, мэдээн дээр үндэслэсэн тул бодитой бус дүгнэлт болжээ гэж үзэж байна. /хэрэгжсэн 13, дутуу хэрэгжсэн 3, огт хэрэгжээгүй арга хэмжээ байхгүй гэж тайлагнасан байна /

Тав. ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулагдаагүй байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээг хөтөлбөрийн хамт тооцож, батлаагүй байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд аймгийн хэмжээнд 14 хүүхдэд 1, 1 багшид 1 компьютер ногдох болсон байна.
- Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж байгаа зарим техник, тоног төхөөрөмжийн чанар нь хэрэгцээ шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байна.
- Хөтөлбөрийн зарим арга хэмжээний биелэлтийг зөвхөн тоон үзүүлэлтээр ерөнхийлөн тодорхойлсон бөгөөд чанарын асуудал орхигдож байна.
- Хөтөлбөрийн явц, хэрэгжилтийн мэдээллийг аймгийн ЗДТГ-т жил бүр тайлагнаагүй байна.
- Хөтөлбөрийн явц, үр дүнд хяналт шалгалт, үнэлгээ хийгдээгүйгээс учирч буй бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга замаа тодорхойлж чадаагүй байна.
- Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа 2018-2020 онд дуусч байгаа учир цаашид шаардагдах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг ирэх онуудын төсөвт тусгах шаардлагатай байна.

Зургаа.ЗӨВЛӨМЖ:**Аймгийн БСУГ-ын дарга Ч.Жаргалсайханд:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, ашиглалтын хугацаа дуусч буй техник, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг ирэх онуудын төсөвт тусгах арга хэмжээ авах.
- Нийлүүлэгдсэн техник тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулахын тулд интернетийн хурдыг нэмэгдүүлэх, ашиглалтын зардлыг шийдвэрлүүлэх.
- Хөтөлбөрийг стратегийн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавин, үнэлгээ хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд тогтмол хугацаанд тайлагнаж байх.

ЕБС-ийн захирал, нягтлан бодогч нарт:

- Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжилтийн явцын талаар БСУГ-т заасан хугацаанд ирүүлж байх
- Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтад байнгын хяналт тавих

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХЛАХ АУДИТОР

Б.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Ж.ЦОГТ